

# ГАДААД ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ



## ОНЦЛОХ МЭДЭЭ

- Зах зээл өнгөрсөн 7 хоногийг сэргэлтэй үдсэн боловч цаашид өсөлтөө хадгалж чадах уу?
- Өнгөрсөн 7 хоногийн өсөлтийн шалтгаан юу байв?

2022.10.24-ний pre-trading session байдлаар

АНУ	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	1 жил
US30	31,157.00	0.24%	3.24%	6.51%	-12.80%
US500	3,765.90	0.44%	2.45%	3.03%	-17.54%
NASDAQ	11,352.73	0.39%	2.72%	0.97%	-26.75%
Европ	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	1 жил
GB100	6,870.00	0.37%	1.62%	-2.65%	-3.26%
DE40	12,731.00	-0.29%	2.36%	1.59%	-18.09%
FR40	6,035.00	-0.85%	1.74%	1.98%	-10.37%
IT40	20,568.00	-0.68%	3.04%	-1.06%	-18.83%
ES35	7,546.00	-1.29%	2.21%	-2.95%	-15.28%
Ази	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	1 жил
JP225	27,022.00	0.54%	1.12%	2.41%	-5.36%
SHANGHAI	3,012.00	-0.89%	-2.37%	-1.29%	-16.57%
CSI 300	3,677.00	-1.77%	-4.38%	-4.13%	-26.14%
SHANGHAI 50	2,423.00	-2.59%	-6.27%	-7.32%	-26.84%
CH50	11,976.95	-2.93%	-6.16%	-7.19%	-25.92%
SENSEX	59,307.00	0.18%	2.40%	0.32%	-2.49%
Эрчим хүч	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	1 жил
Газрын тос (Crude)	84.45	-0.70%	-0.06%	10.90%	2.26%
Газрын тос (Brent)	93.20	-0.28%	-1.72%	12.47%	8.38%
Байгалийн хий	4.85	-2.19%	-19.14%	-30.84%	-17.76%
Шатахуун	2.64	-0.84%	1.79%	15.32%	4.90%
Нүүрс	390.00	-0.50%	-0.64%	-10.48%	69.57%
Түүхий эд	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	1 жил
Алт	1,658.47	0.10%	0.51%	2.27%	-8.25%
Мөнгө	19.38	-0.03%	3.75%	5.70%	-21.06%
Зэс	3.52	-0.04%	1.84%	6.14%	-22.28%
Бонд /10 жил/	Өгөөж	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	1 жил
АНУ	4.1540	0.0580	0.14%	0.27%	2.52%
Англи	4.0500	0.1450	-0.28%	0.56%	2.90%
Швейцар	1.3690	0.0170	-0.02%	0.01%	1.42%
Испани	3.5510	0.0030	0.03%	0.43%	3.02%
Герман	2.4370	0.0430	0.08%	0.46%	2.53%



## **Зах зээл өнгөрсөн 7 хоногийг сэргэлттэй үдсэн боловч цаашид өсөлтөө хадгалж чадах уу?**

S&P 500 индекс 10 сарын эхээс хойш 4% өссөн үзүүлэлттэй байна. Цаашид энэхүү өсөлт үргэлжлэхийн тулд инфляц буурч, ЗГҮЦ-ны өгөөжийн өсөлт зогсох хэрэгтэй. Эдгээр нөхцөлүүд хараахан биелэх болоогүй боловч ойртож байж магадгүй.

## **Өнгөрсөн 7 хоногийн өсөлтийн шалтгаан юу байв?**

### **Компаниудын III улирлын тайлан шинжээчдийн таамгийг давж биелүүлсэн**

Компаниуд III улирлын тайлангаа эхнээсээ танилцуулсан ба одоогоор шинжээчдийн таамагласнаас дээгүүр байна. S&P 500 индексэд багтдаг компаниудын 20% нь тайлангаа ил тод болгосон ба тэр дундаас 73% нь таамагласнаас дээгүүр байв.

Санхүүгийн тайлан энэ улиралд сайн гарч байгаагийн үндэслэл нь хэдийгээр АНУ-ын эдийн засгийн нөхцөл байдал таагүй байгаа ч худалдан авалтын хандлага сайн хэвээрээ байгаатай холбож тайлбарлажээ. АНУ-ын томоохон банкнууд болох J.P. Morgan, Bank of America and Goldman Sachs бүгд худалдан авалт сайн байгаа болон найдваргүй зээлийн түвшин доогуур байгаа талаар онцолсон. Netflix, United Airlines, and Procter & Gamble гэх мэт хэрэглээнээс хамааралтай компаниудын ашигт ажиллагаа шинжээчдийн таамгаас илүү гарчээ.

9 сарын 30-наар тасалбар болгож буй энэ улирлын тайлан магадгүй сайн байж болох ч бодлогын хүүгийн өөрчлөлт эдийн засагт тодорхой хугацааны дараа нөлөөлдгийг санах хэрэгтэй. Иймд, шинжээчид бизнесүүдийн тайлан ирэх хэдэн улиралд муудах төлөвтэй байгааг онцлов. Хөрөнгийн зах зээл энэ жил аль хэдий нь 20 гаруй хувиар уначхаад байгаа нь дээрх таамгийг ханшиндаа урьдчилан тусгасан байх магадлал өндөр юм.


Яагаад гэвэл зах зээл өнгөрсөн мэдээлэл бус ирээдүй дээр үндэслэж ханш өөрчлөгддөг билээ. Иймд, шинжээчид зах зээл удахгүй ёроол ханш тогтон, сэргэлт үзүүлэхэд бэлдэж байна гэж харцгааж байна.



## Хөрөнгийн зах зээлд сүүлийн хэдэн сард хэт их заралт явагдсан тул ханш ёроолоосоо сэргэж байж магадгүй

9 сарын сүүлээр, 10 сарын эхээр хөрөнгө оруулагчдын сэтгэлзүй тааруухан байсан нь магадгүй зах зээл дээрх зарах хандлага дуусаж байгаагийн дохионы илэрхийлэл болсон. Нэг жишээ дурдвал, бух-баавгайн хандлагыг илтгэдэг AAll судалгааны дүн сүүлийн үед 2008 оны хямралын үетэй дөхүү байв. Иймэрхүү гутранги үзэл зарим шинжээчдийг зах зээлийн уналт дуусаж, сэргэж эхэлж байгаа талаар бодуулж байна. Хэдий өнгөрсөн 7 хоногийнх шиг өсөлт түр зуурынх байж болох ч тогтвортой өсөлтийн эхлэл байж бас болох юм.

### Зураг 1. AAll бух-баавгайн хандлагын тодорхойлогч энэ сард хамгийн доод цэгтээ хүрсэн






## Тогтвортой өсөлт бий болохын тулд ямар шалгуурыг давах хэрэгтэй вэ? Хамгийн түрүүнд инфляц тогтмол буух хэрэгтэй

Олон улсын төв банкнууд инфляцыг зорилтот түвшин хүртэл буутал бодлогын хүүг өсгөсөөр байхаа мэдэгдсэн. Иймд, инфляцыг хэдэн сар тогтмол буутал хөрөнгийн зах зээлд дорвитой сэргэлт ирэхгүй. Өнгөрсөн Пүрэв гарагийн АНУ-ын хэрэглээний үнийн индексийн мэдээ таамаглаж байснаас өндөр гарсан тул Холбооны Нөөцийн Санг ойрын хугацаанд бодлогын хүүг бууруулахгүй болов уу гэж үзэж байна. Инфляцын хугарлын цэг, үйлдвэрлэлийн үнэ, нийлүүлэлтийн хэлхээ зэрэг үзүүлэлтүүд бүгд буурсаар байгаа тул ирэх саруудад инфляц буух магадлалыг өсгөж байна.

Бодлогын хүү ингэж хурдтай өсөж байгаа нь үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн ханш унахад хамгийн хүчтэй нөлөөлж байна. Орон сууцны зээлийн хүү өссөнөөр борлуулалт огцом унасан. АНУ-ын 30 жилийн хугацаатай орон сууцны зээлийн хүү 7%-д хүрсэн. Орон сууцны ханш ийнхүү хурдтай унаж байгаа нь инфляц буурахад нөлөөлөх тул хувьцааны хөрөнгө оруулагчид өөдрөгөөр хүлээн авах нэг шалтгаан болж байна.

## Зураг 2. Зээлийн хүү өссөнөөр орон сууцны үнэ буурчээ





## Шинжээчид дээрээс нь ЗГҮЦ-ны өгөөж буурахыг хүлээж байна

Зураг 3. Түүхээс харахад, ЗГҮЦ-ны өгөөж дээд цэгтээ хүрэхэд, бондын өгөөж ирэх 12 сард нь өсжээ



## АНУ-ын төв банкны байр суурь дэлхийн санхүүгийн зээлийг удирдаж байна

Бид өмнө нь Филадельфийн ХНС-ий захирал Харкер төв банк инфляцыг хяналтад автал бодлогын хүүг өсгөнө гэсэн мэдэгдлээр 10 жилийн хугацаатай ЗГҮЦ-ны өгөөж 4.28% хүрсэн. Харин өнгөрсөн 7 хоногт Уолл Стрийт Журнал нийтлэлд ярилцлага өгөхдөө ХНСанг энэ 12 сард бодлогын хүүг 0.5% өсгөж магадгүй талаар дурдсан нь өмнө өсгөсөн дүнгээс бага буюу илүү зөөлөрч байгаагийн илрэл байж магадгүй. Шалтгаан нь төв банк улсынхаа эдийн засгийг илүү хүндрүүлж, хямралд оруулахаас сэргийлж буй аж. ХНС хэт эрт зөөлөн бодлогоо зарлахаас сэргийлж байгаа тул шинжээчдийн үзэж байгаагаар ирэх хавар гэхэд тодорхой болно гэж харж байна.

## Хөрөнгийн болон бондын зах зээлд үүсэж буй боломжууд

ХНС-аас баримталж буй хатуу мөнгөний бодлого ирэх саруудаас зөөлрөх магадлалтай байгаа тул хөрөнгийн зах зээл сэргэх боломжтой.

**Хөрөнгийн зах зээл дээр хамгаалалтын болон бага үнэлгээтэй хувьцаануудаас гадна одоо өсөлт үзүүлэх хувьцаануудыг судалж байх хэрэгтэй.** Хэрвээ ЗГҮЦ-ны өгөөж дээд цэгтээ хүрч, цаашлаад унаж эхэлбэл, өсөлт үзүүлэх технологийн салбарын хувьцаанууд сэргэлт үзүүлнэ. Нэмж санах нэг зүйл нь эдийн засгийн өсөлт буурвал, өсөлтийн хувьцаа эрэлтэд орж магадгүй. Хүнс, эрүүл мэнд зэргийн хамгаалалтын салбарын хувьцаанууд уналтын үед харьцангуй тэсвэртэй байсан тул өсөлтийн хувьцаатай хамт авбал зохиж магадгүй юм.

**Бондын зах зээлийн хувьд богино хугацаат бондыг урт хугацаат хадгаламжийн сертификаттай уялдуулж авахыг зөвлөж байна.** Сүүлийн үед хөрөнгө оруулагчид богино хугацаат хадгаламжийн сертификатыг 1-ээс 2 жилийн хугацаатай бонд сонирхож байна. Эдгээр бондууд урт хугацаанд өндөр өгөөж өгөхөөс гадна, ЗГҮЦ-ны өгөөж буурахад нэмж өсөж магадгүй. Шинжээчид өндөр зэрэглэлтэй засгийн газар эсвэл компанийн хөрөнгө оруулалтын зэрэглэлийн бондыг авахыг санал болгож байна.